

## 1

## АЗИЙН МОНГОЛ УЛСЫН ЕВРОП МАЯГИЙН ШИЛЖИЛТ

**П.Лувсандорж**

Шилжилтээс залхсан монгол хүн олон байгаа бололтой. Нэг хэсэг нь хуучин нийгэмд шилжээд л байсан, шинэ нийгэмд бас л шилжээд баймааргүй байна гээд байхад нөгөө хэсэг нь шилжилтийг цэглэнэ, шилжилт бол хуучинсаг үзэл санаа гээд байх шиг. Аль алин нь шилжилтийг үгүйсгэх гээд байгаа юм.

Гэтэл шилжилтийн эдийн засаг гэсэн шинэ салбар эдийн засгийн шинжлэх ухаанд бий болов. Шилжилт бол дэлхийн нийт хүн амын бараг гуравны нэгийн аж амьдрал, үйл ажиллагааг хамарч буй бодит үйл явц боллоо. Одоо Дэлхийн Банкны тодорхойлсноор, шилжилтийн эдийн засагтай 30-аад орныг нэрлэж болно. Энэ жагсаалтанд ороогүй улс орон бас бий.

Түүнээс гадна шилжилтийн эдийн засагтай орнуудад дан ганц хуучин социалист байсан, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас биш, ердийн хөгжлийн замаар зах зээлийн эдийн засагт шилжиж буй буурай хөгжилтэй "гурав дахь ертөнцийн" орнуудыг нэмэх санал дэвшүүлэх үндэстэй. Эндээс бид ердийн хөгжлийн болон зориуд шилжилтийн гэсэн хоёр ялгаатай замаар зах зээлийн эдийн засагт шилжих бодит үйл явц орчин цагийн дэлхийд өрнөж байна гэсэн глобалист дүгнэлт хийж болно. Ялгаатай нь: Гурав дахь ертөнцийн орнуудад зах зээлийн эдийн засгийн зохион байгуулалтын бүтэц, туршлага бараг бэлэн байдаг. Тэнд хоёр шатлалтай банкны систем, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбаруудын том, жижиг хувийн үйлдвэрүүд байдаг. Засгийн газар нь бас хүү, төсвийн бодлого гэх мэт бодлого, хэрэгсэлүүдээр дамжуулан макро эдийн засгийг удирдах зохион байгуулалтын туршлагатай. Ийнхүү төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай орнуудад бүхэл бүтэн шилжилт хийх, бага, дунд орлоготой хөгжиж буй орнуудад тогтворжилтийг хангах, либералчлал, шинэчлэл хийх үйл явцуудын хооронд ялгаа байгаа биз дээ. Тэр тусмаа эдгээр орон зах зээлийн эдийн засагт бэрхшээл багатай шилжих бизээ.

Монгол Улсад Азийн гэхээсээ Европын загвартай илүү төстэй шилжилт явагдаж байгаа нь олон улсын эрдэмтэдийн судалгаагаар тогтоогдсон юм. Үүнийг тэд нийгэм эдийн засгийн тогтолцооны хувьд ижилхэн, тэгээд бас ЭЗХТЗ-ийн хүрээнд хамтарсан үйл ажиллагаа явуулж байсантай холбон тайлбарлаж байгаа юм. Тэгээд ч Монгол Улс Азийн орон атлаа "Вашингтоны Консенсус" гэж нэрлэгддэг Европын арга замаар макро эдийн засгийн шинэтгэлийг микро түвшнийхээс түрүүлж "дээрээс нь доош" явуулсан онцлогтой, эндээс бас багагүй хохирол хүлээсэн сургамжтай.

Азийн шилжилтийн арга зам нь микро эдийн засгийн шинэчлэлээс эхлэж, зохион байгуулалтын шинэтгэл хөдөө аж ахуйн, аж үйлдвэрийн газруудын шинэтгэл, тэдгээрийн хууль, эрхийн хүрээний шинэтгэл, үнийн шинэтгэлийг хамарсан билээ. Эдгээр шинэтгэлийг макро эдийн засгийн шинэтгэлээс, тухайлбал: төсвийн мөнгөний, гадаад худалдааны шинэтгэлээс өмнө "доороос нь дээш" хэрэгжүүлсэн арга гэж болно. Энэ дараалал нь харьцангуй үр ашигтай барааны зах зээлийг дэмжих, нийлүүлэлтийг урамшуулахад үр нөлөөтэй гэж судлаачид үздэг. Хувийн секторын хөгжлийг дэмжихийн зэрэгцээ улсын үйлдвэрүүдийг шинэ нөхцөлд шилжүүлэх талаар хийсэн алхамууд үр дүнтэй болсон гэдэг. Түүнээс гадна ялгавартай үнэ, мөнгө, санхүүгийн талаар хийж байсан зохицуулалт нь үнийг хяналтаас гаргаж, хүчтэй инфляцийн дарамтанд орсон европ аргаас давуутай гэдэг. Азийн аргыг Монголын шинэчлэлд хэрэглэж болохыг үгүйсгэх үндэс байхгүй.

Эдийн засгийн шинэчлэлийн европ аргын хүрээнд зовлонгийн түргэн, жаргалын удаан гэдэгчлэн өөрчлөлтийг боломжтой тохиолдолд түргэн хийх бодлого явуулсан. Энэхүү шок эмчилгээний ашигтай үр дагаварыг нийгмийн бага зардал гэж үздэг. Гэвч түүнийг тооцоход нэн бэрх ажээ. Шок эмчилгээнийхэн болон градуалистуудын хоорондын мэтгэлцээн үргэлжилсэн хэвээр боловч ихэнх Европын орон эхний стратегийг дагасан байна. Тэдний туршлагаас банкны шинэчлэл, өмч хувьчлал гэх мэт дунд болон урт хугацаанд бүтцийн өөрчлөлт хийгдэх салбарт шок эмчилгээг хэрэглэх боломжгүй нь харагдсан, зарим алдаа дутагдал ч бас ажиглагдсан ажээ.

Эдийн засагч эрдэмтэд: Р.Портес<sup>1</sup>, Нолан, Петер<sup>2</sup> нар шилжилтийн үйл явцад дараах алдаанууд гарсан гэж үздэг. Үүнд:

- микро эдийн засгийнхаас макро эдийн засгийн бодлогод илүү анхаарсан,
- мөнгөний хэтэрхий хатуу бодлого явуулсан,
- хэтэрсэн девальяц хийж, тохирохгүй ханшны бодлого явуулсан,
- улсын үйлдвэрийн газруудыг өргөн хүрээгээр бодлогогүй хувьчилсан,
- ЭЗХТЗ-ийг яарч тараасан нь бүс хоорондын худалдааны уналтанд нөлөөлсөн,
- хуучин тогтолцоог түргэн хугацаанд өөрчлөхөд гарч болох тулгамдсан асуудлуудыг дутуу тооцсон,
- эдийн засгийн амьдрал, баталгааг хангахад Засгийн газрын үүрэг, ролийг

<sup>1</sup> Portes, R. Transformation Traps. Economic Journal, Vol.104, September, 1994

<sup>2</sup> Nolan, Peter. China's Rise, Russia's Fall: Politics, Economics and Planning in the Transition from Stalinism. Macmillan. 1995

дутуу үнэлсэн,

- шилжилтийн явцад "зах зээл" гажуудах тохиолдолд төрөөс хэрэгжүүлэх ёстой арга хэмжээнүүдийн зэрэглэлийг урьдчилан харж чадаагүй,
- улс төрийн тогтвортой орчинг бүрдүүлэхэд тохиолдох хүндрэлийг дутуу тооцоолсон гэдэг.

Эдгээр алдаа Монгол Улсын эдийн засгийн шилжилтийн үйл явцад ямар нэгэн хэмжээгээр гарсан гэх үндэс бий. Эдгээр алдааг дахин давтахгүйн тулд үндэсний судалгааг хөгжүүлэх хэрэгтэй.

Шилжилтийн эдийн засгийн талаар, түүний дотор Монгол Улсын хувьд бидний хийж амжаагүй, бусад орны, олон улсын нэртэй судлаачдын маш сонирхолтой бүтээлүүд байгааг бид бүрэн гүйцэт мэдэхгүй байгаа юм.

## II

Шилжилтийн онол буй, эсэх талаар одоохондоо маргаантай байгаа юм. Хөгжилтэй орнуудын дэлхийд нэртэй эдийн засагчид шок эмчилгээ, аажим шилжилт (градуализм), хоёрыг эс тооцвол тусгайлан томъёолох онол гэж байхгүй, Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны онолуудын хүрээнд багтана гэж үзэж байгаа бололтой. Харин буурай хөгжилтэй орнуудын судлаачид шилжилтийн онол байхаар барахгүй, шилжилтийн эдийн засгийн шинэ салбар шинжлэх ухаан үүсч бий болохыг үгүйсгэх аргагүй. Үүний баталгаа болох нэгэнт тодорхой болсон олон тооны онолын дүгнэлт, практикт нотолгоо бэлхэнээ байгаа юм.

Жишээ нь, улс төрийн шинэчлэл амжилттай явагдаж буй оронд эдийн засгийн либералчлал илүү өндөр түвшинд байдаг гэсэн шинэ онол байхыг үгүйсгэхийн аргагүй. Үүний дээр эдийн засгийн либералчлал улс төрийн ардчилалыг биежүүлдэг гэж нэмж хэлмээр байгаа юм. Энэ бол бас л шинэ онол. Эдийн засгийн ядуу зүдүү амьдралын нөхцөлд хувь хүний улс төрийн эрх яаж бүрэн хэрэгжих билээ дээ.

Өрнөдийн нэрт эдийн засагчид социалист онол, капиталист онол хоёрын дунд юу ч байхгүй, шилжилтийн онол гарч ирэх юм бол "Зах зээлийн социализм" гэгч сэргэж магадгүй гэж болгоомжилж байгаа юм. Тэд зах зээлийн социализм гэгч, жишээ нь, Унгарт бүтэлгүй болсон гэж шуудхан хэлж байгаа юм. Бид хуучин, шинэ нийгмийн уулзвар дээр шилжилтийг биеэр мэдэрч, эдийн засгийн хоёр өөр элементүүд нэгэн зэрэг оршиж байгааг, нэг нь нөгөөг солиж байгааг, заримдаа хоюулаа нийлж эрлийзэж байгааг, заримдаа хоорондоо тэрсэлдэж хоёулаа үгүй болж байгааг нүдээр үзэж байгаа болохоор шилжилт хэдийгээр бэрхшээл, зовлон дагуулж байгаа ч шинжлэх ухааны хувьд сонирхолтой шинэлэг салбар, эрдэмтэн, судлаачдын хүчээ үзэх талбар гэж чин сэтгэлээсээ ухаарч, ойлгож байгаа юм. Аль хэдийнээ шилжилтээс тасарсан хөгжилтэй орнуудын эрдэмтэд, судлаачид энэ бүхнийг шинэ цаг үед бидэн шиг биеэр мэдрээгүй, нүдээрээ үзээгүй байгаа болохоор ухаарч ойлгоход хэцүү л байх. Хүйтэн дайны жилүүдийн үзэл суртлын тэмцэл капитализмд ашигтайгаар шийдэгдсэн шинэ цаг үед шилжилтийн онолоос татгалзах хэрэггүй.

амьдралаас л онол гардаг юм бол хүн төрөлхтний гуравны нэгийн амьдрал, ахуйг тодорхойлж байгааг шилжилтээс онол гарна гэж бид тэдэнд хэлмээр байгаа юм.

Бидний судалгаанаас үзэхэд шилжилтийн эхэн үедээ байгаа монголын эдийг засгийг "номоороо биш" гэмээр. Яагаад гэвэл зах зээлийн сонгодог олон онол одоогоор түүнд таарахгүй байна.

Жинхэнэ зах зээл нь нийгэмд хэрэгцээтэй барааны үйлдвэрлэлд зориулан нөөц баялгийг үр ашигтай хуваарилах, хэрэглээгээ дагасан үйлдвэрлэл явуулах, хамгийн өндөр ашиг олох, өрсөлдөхийн тулд өндөр чанартай шинэ бүтээгдэхүүн гаргах, хамгийн шинэ технологи хэрэглэх, байнга өөрчлөгдөж байдаг нөхцөлд маш түргэн дасах, ямагт уян хатан байх, хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа болон сонголт нь чөлөөтэй байх шинж төлөвийг эдийн засагт суулган ургуулдаг нь нийтлэг. Гэвч эдгээр шинж төлөв зах зээлийн хөгжлийн хэр хэмжээнээс шалтгаалан орон бүрд өвөрмөц, тухайлбал манайд зөвхөн үр хөврөлийн байдалтай.

Зах зээлийн гол субъект, объектууд, тэдгээрийн хооронд байх ёстой хэлхээ холбоо бүхэлдээ биш гэхэд үндсэндээ төлөвшиж, үндэсний эдийн засаг бүхэлдээ үгүй юумаа гэхэд түүний гол, гол салбар нь зах зээлийн эдийн засгийн дээрх шинж төлөвийг олж, тэнд зах зээлийн хуулиуд жинхэнэ ёсоор, "ёстой сурах бичигт байдаг шиг" үйлчилж эхлэсэн тухайд шилжилтийн үе төгслөө гэж болмоор. Тэгэхдээ шилжилтийг ямагт хөгжилтэй холбож ойлгох хэрэгтэй. Эс тэгвээс замаа мэдэхгүй жолооч "зах зээлд" хүрнэ гэсэнтэй нэгэн адил.

### III

Эцэст нь, шилжилтийн үед эдийн засаг дахь төрийн оролцооноос татгалзах буюу хэт багасгах нь шилжилт ба хөгжлийн аль алинд нь хортой том алдаанд хүргэнэ гэж онцлон тэмдэглэмээр байна. Ийм алдаа их төлөв хөгжсөн зах зээлтэй орнуудын туршлагыг шууд хуулбарласнаас гарч байгаа юм. Энэ нь бас Монгол Улс минь ямар орон билээ дээ? гэсэн судалгааны хомсдлоос болж байгаа юм. Бидний ярих дуртай хүчирхэг түншүүдийн (Америк, Япон г.м.) нэр хүндтэй зөвлөхүүд: шинэчлэл сайн явж байна, судалгаа л дутагдалтай байна гэж олон удаа онцолсноос эхнийхийг нь хүлээн авч баярлаад, хоёрдохыг нь мэдэн будилж мартаад байх шиг. Эх орон нэгтэй эрдэмтэн, судлаач бидний үгийг авч баймаар, нэр хүндтэй гадаадын зөвлөхүүдийг хэрэгтэй зүйл дээр нь сонсч баймаар. Өдөр дутмын ажилдаа дарагдсан төрийн хэдхэн түшмэд сэлбэж амжаагүй мэдлэгийнхээ сангаар шилжилтийн нарийн төвөгтэй үйл явцыг бүхнийг мэдэгч болон залж явч болохгүй.

Сурах бичигт зах зээлийн нөхцөлд төрийн оролцоо эдийн засгийн өсөлтийг дэмжих биш, сааруулах нөлөөтэй гэж байдгийг бид мэднэ. Энэ бол хөгжилтэй зах зээлд хамаарагдахаас биш, бүх зах зээлд, тэр тусмаа шилжилтийн үеийн зах зээлд хамаарагдана гэсэн үг огт бишээ. Сурах бичгийн мөрөөр төрийн бодлого явуулж олон тэрбум өмч хөрөнгөө алдаатай хувьчлаж төсөвдөө алдагдалтай, төвлөрсөн хөрөнгө оруулалт хийх чадвар муутай төр байвал түүнийг эдийн засгийн хувьд

ямар төр гэх билээ. Хувьчлалын мөнгөөр хөрөнгө оруулалт хийхгүй, төсвийн цоорхойг нөхөөд байвал хөгжиж буй орнуудад зайлшгүй хэрэгтэй үндэсний эдийн засгийн ирээдүйтэй "ялагч" гэж нэрлэгддэг шинэ салбар, шинэ үйлдвэрлэлийг бий болгох үүргийг монголын төр гүйцэтгэж чадахгүй. Ингэж төрийн эдийн засгийн роль, үүрэг эрс буурч эдийн засгийн хүч чадал нь хэт доройтож төрийн оролцоо, зах зээлийн хоорондын тэнцэл алдагдах аюулд хүрвэл үндэсний эдийн засгийг сэргээх, хөгжүүлэх тухай ярихын аргагүй болно. Хувийн хэвшил хөгжил авчирна гэсэн номыг ерөөсгөл шүтэж улсын сектор хөгжилд хэрэгтэйг мартаж болохгүй, хувьчлахыг мэддэг мөртөө бүтээхийг мартаж төр байж таарахгүй.

Бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, шийдвэр гаргагч хэн бүхэн мэдлэг боловсролоо дээшлүүлж асуудал бүхэнд алсын хараатай ухаалаг хандах шаардлагатай болоод байна. Бодоод үз л дээ. Шилжилтийн үед төрийн үүрэг, ролийг хэт бууруулагч буюу түүнээс татгалзагч аль ч намын хэн ч бай төрийн удирдлагад байж яаж таарах билээ. Төрийн өмчийг зүй бусаар хувьчлах, хувьдаа завшихыг хичээгч нь түүнийг эзэгнэгч байж яаж таарах билээ. Шилжилтийн бэрхшээлтэй хазгай, муруй замаар төрийн оролцоо ба зах зээл хоорондын нарийн төвөгтэй тэнцлийг нягт нямбай барьж чадах нь төрийн жолоонд байх ёстой. Энэ бүхэн бол үндэсний эрх ашгийн асуудал.